*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт*

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА БИНДЭРЬЯА ОВОГТОЙ ЯНЖМААГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ”** | | | | | | | |
| 1. | Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр эрүүл мэндийн байгууллагуудыг орчин үеийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах | Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо | 2024 онд гадаадын буцалтгүй тусламжийн хүрээнд 1,9 тэрбум төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, эрүүл мэндийн байгууллагуудыг хангасан. | Эрүүл мэндийн байгууллагууд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | 2025 оны эхний хагас жилд гадаадын буцалтгүй тусламжийн хүрээнд **5,866,563,872 төгрөгийн** үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, эрүүл мэндийн байгууллагуудыг хангав. Үүнд:<br><br>1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн санд хүсэлт, захиалга өгсний дагуу буцалтгүй тусламжийн хүрээнд **5,753,613,672 төгрөгийн** үнэ бүхий 5 хүчилтөрөгчийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын А/05 дугаар тушаалаар холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. | 2025.01.02 -06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжийн хүрээнд олгосон **112,950,200 төгрөгийн үнэ** бүхий 2,200 ширхэг пульсоксиметрийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын А/09 дүгээр тушаалаар нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. | | |
| 2. | Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс орон, олон улсын байгууллагын техникийн туслалцааны шинэ төслийн санал боловсруулж, шийдвэрлүүлэх | Батлагдаж хэрэгжсэн төслийн тоо, санхүүжилтийн хэмжээ. | Kerry Mining (Mongolia) Limited-ийн **1,0** сая ам.долларын санхүүжилт бүхий "Хавдрын эм худалдан авах" төслийг эхэлсэн. | Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад эх үүсвэрээс буцалтгүй тусламжийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн байна. | 1. Kerry Mining (Mongolia) Limited-ийн **1,0** сая ам.долларын санхүүжилт бүхий "Робот мэс заслын тоног төхөөрөмж худалдан авх" төслийг батлуулаад байна.<br><br>2. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага - ЖАЙКА-ийн санхүүжилтээр шийдвэрлүүлэх зорилгоор "Towards Zero Mortality" Project: Developing a Research Core for the Elimination of Helicobacter Pylori-Related Deaths" ("Нас баралтыг тэглэхийн төлөө: Хеликобактер пилоритой холбоотой нас баралтыг тэглэх судалгааны цөмийг хөгжүүлэх нь") сэдэвт Техникийн хамтын ажиллагааны төслийн саналыг англи хэлээр боловсруулж, журмын дагуу Сангийн яаманд 2025 оны 6 дугаар сарын 6-ны өдөр ТНБД-ын гарын үсэг | 2025.01.02-06.30 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүхий албан бичгээр хүргүүлсэн. Төсөл хэрэгжсэнээр хеликобактерийг илрүүлэх, эмчлэх замаар ходоодны хорт хавдрын тохиолдлыг бууруулах зорилготой. | | |
| **Зорилт 3. "САЙД, ДЭД САЙД, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, УДИРДЛАГАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, АППАРАТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭВИЙН ЯВУУЛАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн 78 дугаар чуулганд оролцуулах | Чуулганы хуралдаанаар хэлэлцсэн асуудлуудаар Засгийн газрын байр суурийг илэрхийлсэн байна. | Жил бүрийн чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлдэг | Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-д заасны дагуу бэлтгэл ажлыг хангаж, чуулганд орлцсон байна. | Дэлхийн эрүүл мэндийн ассабмлейн 78 дугаар чуулганд оролцохтой холбоотойгоор төлөөлөгчдийн Ажлын удирдамж, танилцуулга зэргийг боловсруулж, ГХЯ болон Швейцарийн Холбооны Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яаманд тус тус хүргүүлсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсаас Швейцарийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, НҮБ-ын Женев дэх төв болон бусад олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн хэлэх үгийн төслийг англи хэлээр боловсруулж бэлтгэсэн ба ДЭМБ-ын холбогдох газарт мөн эх бичвэрийг журмын дагуу хүргүүлсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлж үг хэлсэн. | 2025.01.02 -06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Чуулганы үеэр Элчин сайд Д.Гэрэлмаа ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн захиралтай хийх хоёр талын уулзалтыг төвөөс зохицуулж, уулзалтын ярианы сэдвийг бэлтгэн хүргүүлсэн. Мөн Элчин сайд чуулганы үеэр Хөрөнгө оруулалт татах өндөр түвшний уулзалтад Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы өмнөөс оролцож, үг хэлэх бэлтгэл ажлыг хангасан. Үгийн төслийг бэлтгэн хүргүүлсэн. Чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх цахимаар оролцож, үг хэлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангаж, үгийн төслийг бичиж, видео бичлэгийг хийлгэн, ДЭМБ-ын холбогдох нэгж газарт дурьдсан хугацаанд нь хүргүүлсэн. | | |
| 2. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн хорооны 76 дугаар чуулганд оролцуулах | Чуулганаар хэлэлцсэн асуудлуудаар Засгийн газрын байр суурийг илэрхийлсэн байна. | Жил бүрийн чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлдэг | Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”-д заасны дагуу бэлтгэл ажлыг хангаж, чуулганд | Чуулган 2024 оны 10 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд буюу III улиралд зохион байгуулагдана.<br><br>Хугацаа болоогүй. | 2025.10.21 -10.25 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | орлцсон байна. | | | |
| 3. | Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагуудтай тус тусын мандатын хүрээнд хамтран ажиллах | НҮБ-ын төрөлжсөн байгууллагатай хамтран үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн байна | 2023 онд ДЭМБ, Хүүхдийн сан, Хүн амын сантай мандатын хүрээнд идэвхитэй хамтран ажилласан. | Олон талт хамтын ажиллагаа өргөжиж, салбарын хэрэгцээ шаардлагад нийцсэн үр дүнтэй үйл ажиллагаануудыг хамтран хэрэгжүүлсэн байна. | 1. Улирлын томуугийн халдварын тохиолдлууд ихэссэн цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан тус хэлтсээс шуурхай арга хэмжээ авч, ДЭМБ-ын Суурин төлөөлөгчийн газарт нөхцөл байдлыг танилцуулж, албан хүсэлт илгээж, 320,099,750 төгрөгийн үнэ бүхий томуугийн вирусийн эсрэг "OSELTAMIVIR phosphate (Tamiflu)" эмийн захиалга өгч, шуурхай хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн сайдын А/52 дугаар тушаалаар хүлээлгэн өгсөн.<br>2. Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлж буй хавдрын урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн ажлын хүрээнд тус хэлтсээс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар болон Номхон далайн баруун бүсийн төв штабд умайн хүзүүний хорт хавдрын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг танилцуулан **143,794,500 төгрөгийн** үнэ бүхий Хүний папиллома вирусийн зонхилон тохиолдох 14 дэд хэв шинжийн ДНХ-г ялган оношлох оношлуурын багцыг буцалтгүй тусламжийн хүрээнд хүлээн авч Эрүүл мэндийн сайдын А/125 дугаар | 2025.01.02-06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. | | |
| 4. | Эрүүл мэндийн салбарын олон улсын түншлэгчдийн уулзалтыг зохион байгуулах | Түншлэгчдийн уулзалт зохион байгуулагдсан байна. | Өмнөх уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. | Түншлэгч хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, зохицуулалт сайжирсан байна. | Эрүүл мэндийн салбарт хамтран ажилладаг олон улсын байгууллагуудын түншлэлийн уулзалтыг 2025 оны IV улиралд хийхээр төлөвлөөд байна.<br><br>Хугацаа болоогүй. | 2024.01.02 -06.30 | - |
| 5. | Монгол Улс, БНСУ-ын Эрүүл мэндийн яамд хоорондын ээлжит зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах | БНСУ-ын Эрүүл мэндийн яамтай уулзалт зохион байгуулсан байна. | | Хамтын ажиллагааны механизмын хүрээнд тодорхой үр дүнтэй ажлуудыг шинээр санаачилж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. | Бүгд Найрамдах Солонгос Улсад үүсээд буй улс төрийн нөхцөл байдлын улмаас айлын талаас яамд хоорондын зөвлөлдөх уулзалтыг 2025 оны IV улиралд болгон хойшлуулах хүсэлтийг Сөүл дэх Монгол Улсын Элчин сайдын яамаар дамжуулан мэдэгдсэн тул уулзалт зохион байгуулагдаагүй байна. | 2024.01.02 -06.30 | - |
| 6. | Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүл мэндийн үндэсний хороо хооронд 2023-2026 онд хамтран ажиллах Төлөвлөгөө байгуулж, эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагааг бэжхүүлэх | Батлагдсан төлөвлөгөө | Төлөвлөгөө байгуулахтай холбоотой яриа хэлэлцээг айлын талтай хийсэн байна. | Төлөвлөгөөг шинэчлэн байгуулсан байна. | Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүл мэндийн үндэсний хороо хооронд 2023-2026 онд хамтран ажиллах Төлөвлөгөөг монгол, англи хэлээр боловсруулж, ГХЯ-ны Олон улсын гэрээ эрх зүйн газраас хянуулж, байгууллага хоорондын гэрээ байгуулах журамд заасны дагуу холбогдох зөвшөөрлийг тус яамнаас авсан. Энэ онд | 2024.01.02 -06.30 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжих өндөр, дээд түвшний айлчлалын үеэр Төлөвлөгөөнд гарын үсэг зурахаар хүлээж байна. | | |
| 7. | Эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэн байгуулах | Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдаж, хэлэлцээрийн хүрээнд тодорхой үйл ажиллагаа хэрэгжсэн байна. | - | Хоёр улсын эрүүл мэндийн яам хоорондын уулзалтыг зохион байгуулсан байна. | “Эрүүл мэнд, анагаахын шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Сайд Т.Мөнхсайхан 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Анкара хотноо гарын үсэг зурж баталгаажуулсан.<br><br>Монгол Улсын Эрүүл мэндийн яам, БНТУ-ын Эрүүл мэндийн яам хооронд Ажлын хэсгийн анхдугаар уулзалтыг цахимаар амжилттай зохион байгуулж, хамтран ажиллах чиглэлүүдээ тодорхойлсон. Айлын талаас манай яамны Ажлын хэсгийн тус улсад ажлын айлчлал хийхийг урьсан байгаа. Дээрх хэлэлцээрийг батлах тухай Засгийн газрын 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 249 дүгээр тогтоолыг батлуулав. | 2025.01.02 -06.30 | 100% |
| 8. | Эрүүл мэндийн яамны гадаад хамтын ажиллагааны 2024 оны үйл ажиллагааны бичмэл тайланг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх | Эрүүл мэндийн салбарын гадаад хамтын ажиллагааны тайлан ГХЯ- | Хугацаанд нь жил бүр хүргүүлдэг | Эрүүл мэндийн салбарын 2022 оны гадаад хамтын ажиллагааны тайланг 2024 | Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”-д заасны дагуу Эрүүл мэндийн яамны гадаад хамтын ажиллагаана 2024 оны үйл | 2025.01.02 -06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нд хүргэгдсэн байна. | | оны 1 дүгээр сарын эхний 7 хоногт багтаан ГХЯ-нд хүргүүлсэн байна | ажиллагааны бичмэл тайланг 2025 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 2/525 дугаар албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. | | |
| 9. | Гадаад улсуудын болон олон улсын байгууллагын шугамаар сургалт, хурал семинарт оролцох хүмүүсийн холбогдох материалыг судалж, шийдвэрлэх, хамруулах | Шийдвэрлэсэн асуудлын тоогоор илэрхийлэгдсэн байна. | 2024 онд 161 эрүүл мэндийн ажилтныг сургалтад хамруулсан. | Эрүүл мэндийн салбарын бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх түвшний албан хаагчдыг хамруулсан байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар **86** албан хаагчдыг гадаад улс болон олон улсын байгууллагын шугамаар сургалт семинарт хамруулсан. Үүнд:<br><br>1. БНСУ-ын Олон улсын эрүүл мэндийн сангийн Др. Ли Жон-Укийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийн 2025 оны элсэлтэл Монгол Улсаас нийт **33 эрүүл мэндийн ажилтан** 2 жилийн хугацаатай магистрын сургалт болон 6 сарын хугацаатай эмнэлзүйн сургалтад БНСУ-д хамрагдах болсон. Эдгээр ажилтнуудын элсэлттэй холбоотой бүх асуудлыг зохицуулж, шийдвэрлэж ажиллав.<br>2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулагдсан урт болон богино хугацааны биет, цахим сургалт, хурал, семинарт нийт **44** албан хаагчийг хамруулсан.<br>3. НҮБ-ын Хүн амын сангаас зохион байгуулсан богино хугацааны хурал, семинарт **4** албан хаагчийг хамруулсан. | 2025.01.02-06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Оросын Холбооны Улсын Эрүүлийг хамгаалах яамнаас зохион байгуулсан Хүүхдийн яаралтай тусламж сэдэвт сургалтад **5** эмчийг хамруулхаар нэр дэвшүүлээд байна. Сургалт 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулагдах болно. | | |
| 10. | Гадаад улс орнууд, олон улсын байгууллага болон олон улсын төрийн бус байгууллагуудтай хийгдэх уулзалт, ярианы тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Хянагдаж гарсан уулзалтын ярианы тэмдэглэлийн тоо гарсан байна. | 2024 оны 32 ярианы тэмдэглэлийг хөтөлсөн | Уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавигдсан байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах **11** гадаад албан уулзалтыг зохион байгуулж, уулзалтын тэмдэглэлийг хөтлөн, ажлын 3 хоногт багтаан хүлээн авч уулзсан албан тушаалтнаар гарын үсэг зуруулан, уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, холбогдох газар, хэлтсийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллалаа. Үүнд:<br><br>1. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Атул Малхари Готсурвег хүлээн авч уулзсан уулзалтын тэмдэглэл хөтлөв.<br>2. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Тамхины хяналтын суурь конвенцийн нарийн бичгийн дарга нарын газрын дарга Др. Адриана Бланко Маркизог | 2025.01.02 -06.30 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.<br>3. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Бүгд Найрамдах Куба Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Хорхе Феррер Родригесийг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.<br>4. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан , Бүгд Найрамдах Хятад Улсын Рэнжи эмнэлгийн Олон улсын эмнэлгийн захирал Ван Чун Минийг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.<br>5. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Бүгд Найрамдах Польш Улсын Эм, эмнэлгийн хэрэгсэл, биоцидын бүтээгдэхүүний бүртгэлийн газрын дарга Гжегож Цессактай Варшав хотноо хийсэн хоёр талын уулзалтын ярианы тэмдэглэлийг хөтөлж, албажуулав.<br>6. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Дэлхийн банкны Зүүн ази номхон далайн бүсийн хүний хөгжлийн асуудал хариуцсан захирал ноён Альберто Родригезийг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.<br>7. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Эмийн чанарын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хяналтын үндэсний лабораторийн хүчин чадлын сайжруулах ажлын хүрээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүдийг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.<br>8. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат Бүгд Найрамдах Австри Улсын талаас Австрийн Эдийн засгийн танхимын дэд ерөнхийлөгч Филип Гади тэргүүтэй төлөөлөгчдийг Димовсзаг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.<br>9. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Матилда Димовсзаг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.<br>10. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Бүгд Найрамдах Польш Улсын Эм, эмнэлгийн хэрэгсэл, биоцидын бүтээгдэхүүний бүртгэлийн газрын дарга Гжегож Цессакийг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.<br>11. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан НҮБ-ын Хүүхдийн сангийн Зүүн Ази, Номхон Далайн бүсийн Хоол тэжээлийн зөвлөх Роланд Купкаг хүлээн авч уулзах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.<br><br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар зарлигаар баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын хэрэгжилтийг хангаж, гадаад уулзалтуудын ярианы тэмдэглэлийг тухай бүр шуурхай хүргүүлж ажиллав. | | |
| 11. | Гадаад улс орон, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, сунгах асуудлыг судлан шийдвэрлэх | Шийдвэрлэсэн асуудлын тоогоор илэрхийлэгдсэн байна. | 2024 онд хамтын ажиллагааны 9 баримт бичиг байгуулж сунгуулсан. | Эрүүл мэндийн салбар дахь гадаад хамтын ажиллагаа өргөжиж, салбарын хөгжилд түлхэц үзүүлнэ. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах **2** баримт бичгийг шинээр байгуулав.<br><br>1. "Эрүүл мэнд, анагаахын шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр байгуулав. Хэлэлцээрийг Засгийн газрын 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 249 дүгээр тогтоолоор батлуулав.<br>2. Монгол Улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Бүгд Найрамдах Польш Улсын Эм, эмнэлгийн хэрэгсэл, биоцидын бүтээгдэхүүний бүртгэлийн газар хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг | 2025.01.02-06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025 оны 3 дугаар сарын 13-ны байгуулав. | | |
| 12. | Гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудтай хийгдэх ёслолын арга хэмжээг зохион байгуулах | Шийдвэрлэсэн асуудлын тоогоор илэрхийлэгдсэн байна. | 2024 онд ёслолын арга хэмжээ 5-ыг зохион байгуулсан | Ёслолын арга хэмжээ журмын дагуу зохион байгуулагдсэн байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах **2** ёслолын арга хэмжээг зохион байгуулав.<br>1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын төвийн нээлтийн ёслолын арга хэмжээг зохион байгуулав.<br>2. Азийн хөгжлийн банкаар дамжин Ядуурлыг Бууруулах Японы Сан (JFPR)-гийн 5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх" төслийн хүрээнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо, шинжилгээ хийхээр бүрэн тоноглогдсон нүүдлийн эмнэлэг бүхий 2 тусгай зориулалтын автомашиныг хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээг зохион байгуулав. | 2025.01.02-06.30 | 100% |
| 13. | Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын гадаадын улс орнуудад хийх айлчлал, хурал семинарт оролцох бэлтгэлийг хангаж, зохион байгуулах | Хэрэгжсэн айлчлал, хурал семинарын тоогоор илэрхийлэгдсэн байна. | - | Айлчлал, хурал семинарт оролцож, хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхойлогдсон байна. | 1. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы Бүгд Найрамдах Турк Улсад хийх айлчлалын бэлэн байдлыг хангаж ажиллав.<br>2. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы Бүгд Найрамдах Чех Улс болон Бүгд Найрамдах Польш Улсад | 2025.01.02-06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хийх айлчлалын бэлэн байдлыг хангаж ажиллав.<br>3. Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатын 2025 оны 4 дүгээр сарын 3-4-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин Улсад зохион байгуулагдах Өвчтөний аюулгүй байдлын асуудлаарх дэлхийн сайд нарын 7-р дээд хэмжээний уулзалтад оролцох бэлтгэл ажлыг зохион байгуулж ажиллав. | | |
| 14. | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөгөөний биелэлт, тайлан мэдээг нэгтгэн гаргах | Шийдвэрлэсэн асуудлын тоогоор илэрхийлэгдсэн байна. | Хууль тогтоомжийн биелэлтийг хугацаанд нь тогтмол гаргадаг. | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөгөөний биелэлт, тайлан мэдээг нэгтгэн гаргаж, холбогдох нэгжүүдэд хүргүүлэн биелэлтэд тавих хяналт сайжирсан байна байна. | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөгөөний биелэлт, тайлан мэдээг нэгтгэн цаг тухай бүрт холбогдох газруудад тогтмол хүргүүлэн ажиллав. | 2025.01.02-06.30 | 100% |
| **Зорилт 4. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 37-р зүйлийн 37.1.8-д заасны дагуу “Өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх” нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллана. | Нийтлэг үүргээ зөрчилгүйгээр хэрэгжүүлсэн байна. | Төрийн албаны хууль тогтоомжийг мөрдлөг болгож ажилладаг. | Төрийн албаны тухай хуулийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллана. | Төрийн албаны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 2025.01.02 -06.30 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Албан тушаалын чиглэлээр олон улсын богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Мэргэжилтэй холбогдолтой сургалтад хамрагдсан байх | - | Олон улсын эрүүл мэндийн чиглэлээр өөрийн мэргэжилийн ур чадвар дээшилж мэдлэгтэй болно. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн төвөөс 2025 оны 3 дугаар сард зохион байгуулсан Нийгмийн эрүүл мэндийн онц ноцтой байдлын үеийн шуурхай удирдлагын төвийг ажиллуулах цогц сургалтад хамрагдаж төгссөн. Сертификат авсан. | 2025.01.02-06.30 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| Хэлтсийн дарга | Б.Янжмаа / ........................ / | 2024.06.10 |
| *(Албан тушаал)* | *(Нэр, гарын үсэг)* | *(Огноо)* |

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС (ЗАГВАР)

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лабораторийн байранд Эм шинжлэх лабораторийг шинэчлэн зохион байгуулж, олон улсын стандартад нийцэх лабораторийн модуль угсрах ажлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлыг зохицуулах | Эрүүл мэндийн сайд | Лаборатори ашиглалтад орсон байна. | - | Лабораторийн ерөнхий зураг төсөл, зургийн нарийвчилсан даалгаврын дагуу олон улсын тендер зохион байгуулагдаж, ажил гүйцэтгэгдсэн байна. | 2025.01.01 | 2025.12.31 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**

ГХАХ- ийн дарга — Б.Янжмаа/ ........................... / — 2025.06.06

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ТЗУГ-ын дарга — Б.Батбаяр/ ........................... / — 2025.06.06

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*